

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТМОЛ ТҮГЭЭМЭЛ ХЯНАЛТАНД ХҮРГЭХ МЭДЭЭЛЭЛ

Танилцуулга

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид Комисс гэх) ХЭҮБ-ын ОУЗХ-ны А статусын магадлан итгэмжлэл бүхий бие даасан, үндэсний хүний эрхийн байгууллага бөгөөд бүрэн эрхийг нь 2000 онд баталсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар баталгаажуулсан. Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлыг сүүлийн 4 жилийн (2005-2009 он) хугацаагаар дүгнэж, холбогдох мэдээллийг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 5/1 дугаар тогтоолын дагуу Тогтмол түгээмэл хяналтанд хүргүүлж байна.

Үндэсний эрх зүйн орчин

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу Монгол Улсын соёрхон баталсан болон нэгдэн орсон олон улсын гэрээнүүд нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Улсын Их Хурал 2003 онд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа-механизмыг бүрдүүлэх, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх, үр нөлөөтэйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын чухал баримт бичиг болох “Монгол Улсад Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөбөр”-ийг баталсан.

3. Улсын Их Хурал 2005 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг баталсан бөгөөд “Хүний эрхийг бэхжүүлэх, ардчилсан засаглалын хөгжүүлэх” тухай өөрийн орны онцлогийг тусгасан 9 дэх зорилтыг нэмж тодорхойлсноороо онцлогтой. Мөн Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг 2008 онд баталсан. Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Мянганы хөгжлийн зорилтууд, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт өгч, Эдийн засаг, нийгмийн шинэтгэлийн бодлого, технологи, инновацийн үзэл баримтлал, урт болон дунд хугацааны стратеги, төсөөлөл боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох чиглэлээр Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороог шинээр байгуулсан нь дэвшилтэт алхам болсон байна.

4. Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т шүүх хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн болохыг хуульчилсан ба Монгол Улсын Дээд Шүүх 2008 онд “Олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ,

зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тогтоолыг баталсан нь хүний эрхийг хамгаалахад чухал алхам болсон байна.

Олон улсын хүний эрхийг хамгаалах механизмуудтай хамтарч ажиллаж буй байдал

5. Монгол Улс нь НҮБ-ын Хүний эрхийн суурь 8 гэрээний 7-г нь соёрхон баталсан (ИУТЭТОУП, ЭЗНСЭТОУП, АӨАБХУТОУК, ЭЭАБХУТОУК, ЭШХХБХЯШЭОУК, ХЭТОУК, ХБХЭТОУК). Аливаа орон олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах, түүний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гэрээний хороодуудад тайлагнах нь нэн чухал. Олон улсын гэрээгээр хүлээсэн энэхүү үүргээ тогтоосон хугацаанд биелүүлэхгүй байгаа талаар Комисс Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007 оны илтгэлд тусгаж, холбогдох зөвлөмж гаргаж улмаар энэ нь Засгийн газрын зүгээс Хүүхдийн эрхийн тухай конвенцийн ээлжит 3, 4 дүгээр илтгэл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын ээлжит 5 дугаар илтгэлийг тус тус холбогдох хороодод хүргүүлэхэд хөшүүрэг болж чадсан. Засгийн газраас олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийн талаарх үндэсний илтгэлүүдийг боловсруулахад 2007 оноос эхлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг авч байгаа ахиц гарав. Түүнчлэн, Засгийн газар 2009 онд “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай үндэсний илтгэл бэлтгэх тухай журам” -ыг баталсан нь үндэсний илтгэлийг тогтоосон хугацаанд боловсруулан хариуцах этгээдийг тодорхой болгож, төрийн бус байгууллагуудын саналыг авч байх зохицуулалтыг тусгасан нь иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангасан чухал алхам болсон болно.

6. Тусгай илтгэгчдийн механизм нь хүний эрхийн нөхцөл байдлыг илтгэх чухал холбоос болж байдгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар эрүү шүүлтийн асуудал (2005 он), сурч боловсрох эрх (2009 он) хариуцсан тусгай илтгэгч нарыг урьж нөхцөл байдлыг танилцуулсан.

Хүний эрхийн асуудлууд

7. Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүрт уучлал үзүүлнэ гэдэг мэдэгдэл хийсэн нь цаазаар авах ялыг de facto халсан шийдвэр болсон. Энэ нь Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2 дугаар бүлгийн 2.1.1-д заасан хүний амьд явах, уучлал хүсэх эрхийг уучлан амь хэлтрүүлэх, гүйцэтгэлийг хойшлуулах, уг ялыг оногдуулдаг хэргийн төрлийг цөөрүүлэх, хэтдээ ялын төрлөөс хасах замаар хангахад чухал ач холбогдолтой. Улсын Их Хуралд

өргөн барьсан Эрүүгийн төрөлжсөн хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуультай харьцуулахад ялын дээд хэмжээ оногдуулах гэмт хэргийн тоог 5-аар багасгаж, зөвхөн хүндрүүлэх нөхцөлтэйгээр хүнийг санаатай алах (105 дугаар зүйлийн 105.2-р хэсэг) болон төр буюу нийгмийн зүтгэлтний амь насанд халдах (261 дүгээр зүйлийн 261.1-р хэсэг) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулахаар тусгасан нь дээрх хөтөлбөрийн хэрэгжилтэнд ахиц гарахын илрэл мөн.

8. Комиссын тогтмол хяналт шалгалт, судалгаа, Монголын Улсын хуулийн байгууллагуудын хүчин чармайлт, Эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай илтгэгчийн зөвлөмж зэрэг идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагааны явцад албан тушаалтнуудын хүний эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаархи мэдлэг нэмэгдэж, хүний эрхийн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох механизм бэхжиж байна. Цаашид энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс гэмт хэргийн субъектын тодорхойлтыг ЭШХХБХЯШЭОУК-ийн зохицуулалтанд бүрэн нийцүүлэх, түүний нэмэлт протоколыг соёрхон батлаж үндэсний урьдчилан сэргийлэх механизм бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

9. Олон улсын хүний эрхийн гэрээгээр баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангахын зэрэгцээ ИБУЭТОУП-ын 21 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарах шаардлагатай болохыг 2008 оны 7 сарын 1-ний өдөр болсон олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нотолсон. Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомжийг нарийвчлан судлаж боловсронгуй болгох, олон улсын хамтын нийгэмлэгээс сайн туршлага судлах зэрэг ажил хийгдэж байна. Мөн Комиссоос гаргасан илтгэлийг үндэслэн УИХ-аас томилсон хоёр ажлын хэсэг ажиллаж, гарах дүгнэлтийн дагуу цаашид авах арга хэмжээ тодорхой болно.

10. Ядуурлын түвшин 35 орчим хувьтай , уламжлалт аж ахуй нь нийгэм, эдийн засгийн хөгжилтэй бүрэн уялдаагүй, орон нутаг руу чиглэсэн төрийн бодлого сул зэрэг нь иргэдийг хот суурин газарт олноор шилжин суурьшихад хүргэж байна. Орон нутагт ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн арга хэмжээ үгүйлэгдэж байна.

11. Дотоодын болон импортын хүнсний барааны чанарын хяналт алдагдсан нь иргэд хоол хүнснээс шалтгаалсан өвчлөлт, хордлого, амь насаа алдах зэрэг удаа дараагийн тохиолдлоор нотлогдож байна. Энэ асуудал даамжирвал үндэсний аюулгүй

байдалд нөлөөлөхүйц сөрөг үр дагавартайг анхааралдаа авч, төрөөс онцгой анхаарах шаардлагатай байна.

12. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хөдөлмөрийн үнэлгээг хоногоор бус цагаар тооцох, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр зорьж буй нь иргэдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөв алхам болж байна. Сүүлийн жилүүдэд ажлын байр тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаа ч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналт нь өсөн нэмэгдэж буй хурдцаа гүйцэхгүй байна.

13. Засгийн газар 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 12 жилийн боловсролын тогтолцоонд шилжих бодлогыг хэрэгжүүлснээр ерөнхий боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцүүлэн, дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц боловсон хүчин бэлтгэхэд анхаарч байна. Гэвч хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагын үүднээс эн тэргүүнд боловсролын тогтолцоон дахь боловсон хүчнийг мэргэшүүлж, хүүхдэд ээлтэй орчин бий болгох, хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, хүмүүжлийн шинэ аргаар боловсрол олгоход анхаарах хэрэгтэй байна.

14. Иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах бодлогын хүрээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний эх үүсвэр тодорхойгүй бус байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлуудыг гадаадын тусламж, хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх нь чухал хэдий ч эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

15. Аливаа түвшинд жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо нэн чухал юм. 2007 онд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна” гэж заасныг хүчингүй болгосон нь Мянганы хөгжлийн зорилго 3-ын зорилт 6-д хүрэх үйл явцаас тодорхой хэмжээнд ухарсан алхам болсон. Улсын Их Хуралд өргөн барьсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд нам эвслээс нэр дэвшигчдийн 15-аас доошгүй хувь нь эмэгтэй байна гэж тусгасан нь хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт болж байна. Түүнчлэн, 2009 оноос жендэрийн тэгш байдал, гэр бүлийн хүчирхийллийн талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгоход төрөөс ихээхэн

анхаарч ажилласны дүнд холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн бариад байна.

16. Монгол Улсын Засгийн газар хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлж, хүүхэд хамгаалалын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн сан, бусад олон улсын байгууллагууд идэвхийлэн ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги”-ийг боловсруулсан хэдий ч батлах явц удаашралтай байна. Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт сул, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн эрх зөрчигдсөөр байгаа нь хүүхэд хамгааллын тогтолцоог нэн даруй боловсронгуй болгох шаардлагатайг илэрхийлж байна.

17. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, Хүний эрхийн Үндсэний Комисс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн байгууллагуудын идэвхитэй хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улс 2009 онд ХБХЭТОУК-г, түүний Нэмэлт Протоколын хамт соёрхон баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний байгууллага болон бусад салбарын төлөөллийг хамарсан, үндэсний бие даасан, хяналтын механизмыг Засгийн газрын бүтцэд бий болгох замаар конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өдөр тутмын амьдралд бүрэн дүүрэн оролцоход орчны болон мэдээллийн хүртээмжгүй байдал сөргөөр нөлөөлж байгаа тул иргэдийн идэвхтэй оролцоо, байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эерэг орчныг бүрдүүлэхэд анхаармаар байна.

18. Төрөөс ахмад настныг орон сууцаар хангах, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх зэргээр ахмад настны амьдрал ахуйг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тууштай авч байна. Гэхдээ ахмадуудад төрөөс үзүүлж буй үйлчилгээний хүрээ нийгмийн халамжаар хязгаарлагдаж байна. Иймээс эдгээр бүлэг хүмүүсийг нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд бүрэн дүүрэн татан оролцуулах бүхий л боломжийг судлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

19. Монгол Улсад үндэсний цөөнх иргэд /Казах, Тува/-ийн эрхийг хангах хүрээнд өв уламжлал, хэл соёлоо хадгалж үлдэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч мэдэгдэм ахиц гарахгүй байна. Улсын Их Хуралд өргөн барьсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуул /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд нам эвслээс 2-оос доошгүй нэр дэвшигч нь казах иргэдий төлөөлөл байхаар тусгасан нь үндэсний цөөнх иргэдийн

шийдвэр гаргах түвшин дэх оролцоог хангахад чухал ач холбогдолтой болох нь эргэлзээгүй.

Дээрхи нөхцөл байдалд үндэслэн Комисс нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг саналыг хүргэж байна. Үүнд:

1. Иргэний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд ИБУТЭТОУП-ын хоёр дугаар Нэмэлт протоколыг соёрхон батлаж цаазаар авах ялыг ялын төрлөөс хасах талаар Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх;

2. ЭШХХБХЯШЭОУК-ын Нэмэлт протоколыг ойрын хугацаанд соёрхон баталж тус баримт бичгийн дагуу байгуулах үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг Комиссын бүтцэд бий болгох;

3. ХБХЭТОУК дагуу үндэсний бие даасан хяналтын механизмыг нэн даруй Засгийн газрын бүтцэд бий болгох, олон талын оролцоог хангах;

4. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлийн зохистой хоол хүнсээр хангагдах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, хорт болон аюултай бодис, хаягдал хариуцсан тусгай илтгэгч нарыг урих;

5. Төвөөс хөдөө орон нутагт руу чиглэсэн бодлогыг эрчимжүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын бие даасан байдлыг хангах;

6. Эмэгтэйчүүд, үндэстний цөөнхийн төлөөллийн шийдвэр гаргах түвшний оролцоог хувь тогтоох замаар эрх зүйн хүрээнд баталгаажуулах;

7. Хүүхэд хамгаалын тогтолцоог боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх;